


**СҮХБААТАР ДҮҮРГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн нийт байгууллага, хэлтэс нэгжийн хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 5316 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэгдэж хариу өгсөн 5152, судлагдаж байгаа 107 өргөдөл хүсэлт байна. Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 58 өргөдөл хүсэлт байгаа бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 97.00 хувьтай байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 20 цаг 58 минут байна.



2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, өдөрт нь багтаан шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй болон бусад 2268 зөрчил бүртгэгдсэн байна.

Өргөдөл гомдлын мэдээ тайланг улирал, сар болон тухай бүр гаргаж дээд шатны байгууллагад тайлагнан Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурал, Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай хурлаар хэлэлцүүлэн ажиллаж байна.

Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл:

Санхүү татварын тухай - 1186

Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааны тухай-328

Ажилд орох тухай- 259

Газар чөлөөлөх тухай -245

Ажлаас чөлөөлөгдөх тухай-230

Ажлаас Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай-186

Газрын маргаантай асуудлыг шийдвэрлэх тухай-151

Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай-121

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай-120

Бусад 2490 өргөдөл хүсэлт байна.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар нийт 1323 өргөдөл хүсэлт ирсэн. Үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 1286, судлагдаж байгаа 26, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 11 өргөдөл хүсэлт байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн явц 98,00 хувьтай байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 11 хоног 22 цаг 18 минут байна.

Дээрх хугацаанд өргөдөл хүсэлтийг өдөрт нь багтаан хүлээж аваагүй, шилжүүлээгүй, явцын тэмдэглэл хөтлөөгүй гэх мэт 318 зөрчил бүртгэгдсэн байна.

Уг зөрчлийг бууруулах тал дээр анхаарч ажиллах талаар албан хаагч бүрт өдөр тутамд мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Өргөдөл	гомдлыг	хандалтаар	нь	авч	үзвэл
					Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай -122
					Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ павильон, ил задгай худалдаа үйлчилгээний тухай-82
					Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааны тухай-82
					Хог цэвэрлэгээ тээвэрлэлтийн тухай-68
					Явган хүний зам, талбайн тохижилтын тухай-57
					Бусад-974

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Тус хэлтэст 2024 онд хугацаанд 983 иргэнээс өргөдөл гомдол санал хүсэлт ирүүлсэн байна.

Үүнээс иргэний 983 өргөдлийг ажлын 1-10 хоногийн хугацаанд шийдвэрлэж, өргөдөл гомдол санал хүсэлтийг хуулийн хугацаанд судалж шийдвэрлээд байна.

Шийдвэрлэлт 93,8 % үзүүлэлттэй байна.

1. Хүрээлэн буй орчин тохижилт үйлчилгээтэй холбоотой 427 өргөдөл
2. Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай 145 өргөдөл
3. Барилга хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай 30 өргөдөл
4. Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай 147 өргөдөл
5. Төрийн үйлчилгээ, төрийн байгууллагын үйл ажиллагааны тухай 21 өргөдөл
6. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний тухай 10 өргөдөл
7. Нийгмийн хөгжил, нийгмийн хамгаалалын тухай 1
8. Зөрчил 100 өргөдөл

1. Хүрээлэн буй орчин тохижилт үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол

2024 оны жилийн эцсийн байдлаар 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, 01 дугаар сарын 30-ны өдөр, 3 дугаар сарын 22-ны өдөр, 4 дүгээр сарын 05-ны өдөр, 5 дугаар сарын 10-ны өдөр, 2024 оны 07 дугаар сарын 04-ны өдөр, 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдөр, 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр, 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, нийт 12 удаагийн их цэвэрлэгээний ажил явагдаж давхардсан тоогоор 17900 аж ахуй нэгж байгууллага, 98344 иргэн оролцож 690388м² талбайн цас мөс, хог хаягдлыг цэвэрлэж 56 машин 1126 рейсээр нийт 3927,96 тонн хог хаягдлыг тээвэрлэлээ.



2024 оны 01 дүгээр сард дүүргийн 1-20 дугаар хороодын айл өрх, аж ахуй нэгж байгууллагын хог тээврийн нарийвчилсан хуваарийг Засаг даргын орлогчоор батлуулан Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, үйлчилгээний ажилд Хороодын олон нийтийн байцаагч нараар байнгын хяналт тавьж байна.

Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн ханган Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйлчилгээг тогтмол хийлгэн иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.



Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, талбай гуу жалганд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, гэрлийн шонг бохирдуулж наасан зарлал хуулах, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил хашаа, талбай, нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг ачиж тээвэрлэх, халтиргаа гулгааг арилгах чиглэлээр иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Цагаан сарыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ”-ний аяныг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 02 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгууллаа.

Аяны хүрээнд дүүргийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар албан даалгавар, аяны удирдамжийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хүргүүлж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдөр бүх нийтийн их цэвэрлгээ зохион байгууллаа.

2. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний 5 байгууллага "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ, "Сүхбаатар дэвшил менежмент" ААТҮГ, "Сүхбаатар тохижилт" ХХК, "Наши трейд" ХХК, "Шинэ цагийн зам" ХХК 21 техниктэй ажиллаж, хариуцсан бүсийн цэвэрлэгээнээс гарсан 423тн хар цасыг тээвэрлэсэн.

3. Халтиргаанаас сэргийлж авто замын зорчих хэсэгт нийтдээ 33,5тн давс, 44м3 хайрга цацсан.

4. Дүүргийн хэмжээнд 120тн давс, 57тн бодис, 28м3 хайрга дайрганы нөөцтэй.

5. Дүүргийн 13 дугаар хорооны далан дунд үүссэн их хэмжээний цас, мөс, үүсмэл хог, барилгын хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлэх ажлыг 2024 оны 01 дугаар сарын 29-ний өдрөөс "Сүхбаатар дэвшил" ОНӨААТҮГ хийж гүйцэтгэж байна.

2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар том оврын Хово машинаар нийт 780 рейс буюу 9360тн хог хаягдал, хар цасыг тээвэрлэлээ. Цэвэрлэгээ, тээвэрлэлтийн ажил үргэлжилж байна.

6. Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны далан дагуу хуримтлагдсан 30 тонн хур хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.

7. Гэрэлтүүлгийн 46 Шонд тагжуулалт, 286 гэрэлтүүлгийн толгойн засвар, 3 самбарын коллектор, 3 самбарт соронзон пускатал солих, 7 ширхэг шит засах, 181м Сип утас сольсон.





Эзэнгүй нохой муур барих ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж дүүргийн 11 дүгээр хороо-4 муур, 12 нохой, 12 дугаар хороо-2 муур, 20 нохой, 13 дугаар хороо-11 муур, 17 нохой, 14 дүгээр хороо-35 нохой, 16 дугаар хороо-32 нохой, 17 дугаар хороо-4 муур, 16 нохой нийт 158 нохой, 33 муурыг барилаа.



Мөн 2024 оны 01 дүгээр сард-644 ширхэг эзэнгүй нохой, муур 2 дугаар сард 318 нохой муур, 3 дугаар сард 1001 нохой, 4 дүгээр сард 891, 5 дугаар сар 1100, 6 дугаар сард 868, 7 дугаар сард 616, 8 дугаар сард 167, 9 дүгээр сард 102, 10 дугаар сард 215, 11 дүгээр сар 721, 12 дугаар сар 315 нийт 6958 нохой муур устгасан



2.Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай өргөдөл, гомдол

Зам тээвэр, дэд бүтэц, инженерийн байгууламжийн тухай ирсэн санал, хүсэлт гомдлыг шийдвэрлэхдээ Нийслэлийн шуурхай удирдлагын төв, Нийслэлийн замын хөгжлийн газар, Улаанбаатар зам засвар ОНӨААТҮГ болон мэргэжлийн инженерийн байгууламж хариуцсан байгууллагад тухай бүр албан бичиг болон хариуцсан дуудлага хүлээн авах төвд дуудлага өгч засвар үйлчилгээнд хяналт тавин иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.

3. Барилга хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай өргөдөл гомдол

Барилга хот байгуулалт, ерөнхий төлөвлөгөөний тухай ирсэн өргөдөл гомдлыг Газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцан холбогдох дээд шатны байгууллага болон дүүргийн газар зохион байгуулалтын алба, мэргэжлийн хяналтын хэлтэс болон инженерийн байгууламж хариуцсан мэргэжлийн байгууллагад хандан шийдвэрлүүлж иргэнд хариу өгч ажиллаж байна.

4.Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай өргөдөл гомдол

Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбоотой гомдлыг Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн эд хөрөнгийн тухай хуулийн дагуу газар дээр нь очиж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажилласан

Үүнд: -Хог тээвэрлэлт

-Гадна орчны цэвэрлэгээ, үйлчилгээ

-Төлбөр үндэслэлгүй нэмсэн

-Хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ


-Тайлангийн хурлаа хийхгүй зөрчил

2 дугаар улирлын байдлаар иргэдээс дараах өргөдөл гомдол ихээр ирсэн байна. Үүнд:

- 1 Гудамж талбайн гэрэлтүүлэг түүнтэй холбоотой зөрчил
- 2 Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны тухай
- 3 Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай
- 4 Хог тээвэрлэлт, түүнтэй холбоотой зөрчил
- 5 Золбин нохой, түүнтэй холбоотой зөрчил
- 6 Өөрийн эзэмшлийн газарт ёуурийн ажил эхлэх зөвшөөрөл

1. Гудамж талбайн гэрэлтүүлэг түүнтэй холбоотой зөрчил

Иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу гэрэлтүүлгийн ашиглалт хариуцсан байгууллагад утсаар мэдэгдэх мөн албан бичгээр хандаж засварлуулах ажлыг зохион байгуулж байна.



1. Дүүргийн нутаг

дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн 7450 ширхэг гэрэлтүүлэг, төв авто зам дагуух 4437 ширхэг гэрэлтүүлгийн арчлалт хамгаалалтыг Гэрэлтүүлэг чимэглэл ХХК, Спецшл тим ап ХХК, БМЖЛ ХХК-иуд хариуцан ажиллаж байна. Гэрэлтүүлгийн асалт, арчлалт хамгаалалтын ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан нөхцлийн дагуу сард 3 аас доошгүй удаа хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн мэдээллийн дагуу засвар үйлчилгээг тогтмол хийж байгаа бөгөөд гэрэлтүүлгийн асалт 99,2%-тай байна.

2. Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбооны тухай өргөдөл гомдол

Орон сууц нийтийн аж ахуй, сууц өмчлөгчдийн холбоотой гомдлыг Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн эд хөрөнгийн тухай хуулийн дагуу газар дээр нь очиж тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн ажилласан

Үүнд: -Хог тээвэрлэлт

-Гадна орчны цэвэрлэгээ, үйлчилгээ

-Төлбөр үндэслэлгүй нэмсэн

-Хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ

-Тайлангийн хурлаа хийхгүй

3. Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны А/10 дугаар, А/118, А/273 дугаар захирамжаар 2024 оны 01 дүгээр сараас хороо тус бүр дээр 2 иргэдийн бүлгийн ажилчид сар бүр 850 000 төгрөгийн цалин өгч хорооны нутаг дэвсгэрийн ил задгай түүвэр хог хаягдлыг цэвэрлүүлж байна.



Дүүргийн 1-20 дугаар хорооны нийтийн эзэмшлийн 164 байршлын 420158м2 зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК хийж ажлын гүйцэтгэлд сард 4-5 удаагийн давтамжтайгаар хяналт тавин ажиллаж байна.



Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 63 дугаар тогтоолын хэрэгжилтийн ханган Сүхбаатар дэвшил ОНӨААТҮГ, Сүхбаатар тохижилт ХХК, Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ-н цэвэрлэгээ, хог тээвэрлэлтийн үйлчилгээг тогтмол хийлгэн иргэнд хариу мэдэгдэн ажиллаж байна.

4. Хог тээвэрлэлт, түүнтэй холбоотой зөрчил

Сүхбаатар Дэвшил ОНӨААТҮГ нь хог тээвэрлэлтийн зуны хуваарьт шилжиж дүүргийн 3, 4, 5, 7, 8, 10, 11, 19 дүгээр хороодын хог тээвэрлэлтийг өглөөний 04 цагаас 05 цагийн хооронд эхлүүлэн төв зам болон ачаалал ихтэй байршилын ачилтыг түрүүлж хийх үүрэг чиглэлийг өгж ажиллаж байна.

Мөн 13, 18, 20 дугаар хороодын хог тээвэрлэлтийг өглөөний 06 цагт эхлүүлэн ажиллаж байна.

Сүхбаатар дэвшил менежмент ААТҮГ 6, 9 дүгээр хороодын хог тээвэрлэлтийг зуны хуваарийн дагуу өглөө 02:00 цагаас, 12, 14, 16 дугаар хороодод бусад автомашин өглөө 05:00 цагаас ачилтуудыг хийж эхэлдэг.

Сүхбаатар тохижилт ХХК 1, 2 дугаар хороодын хог тээвэрлэлтийг 19.00-07:00 хүртэл, 15, 17 дугаар хороодын хог тээвэрлэлтийг өглөө -06:00 цагаас тээвэрлэж байна.

Нийгмийн хөгжил хамгааллын чиглэлээр:

Тус хэлтэст нь 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар <https://erp.ulaanbaatar.mn/> өргөдөл, гомдлын хэсгээр 189 өргөдөл, хүсэлт хүлээн авч ажиллаж байна. Үүнд:

№	Өргөдөлийн утга	Нийт ирсэн өргөдлийн тоо	Үүнээс	
			Хугацаандаа шийдвэрлэсэн	Хүлээгдэж байгаа
1.	Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай	19	19	
2.	Хүүхдэд үрчлэлт тогтоох тухай	46	46	
3.	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд харгалзан дэмжигч тогтоох тухай	29	29	
4.	Ахмадын асрамжийн төвд асруулах тухай	4	4	
5.	Гэр хүссэн	31	31	
6.	Буцалтгүй мөнгө, яаралтай тусламж, эмчилгээ, нийгмийн халамж хүссэн	32	32	
7.	Тэмцээний зардалд дэмжлэг хүссэн	13	13	
8.	Талархал	4	4	
9.	Гомдол	3	2	1
10.	Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай	2	2	
11.	Барилга, байгууламж барих, өргөтгөх тухай	1	1	
12.	Нийтийн эд аж ахуйн ашиглалт, үйлчилгээний тухай	4	4	
13.	Том оврын тээврийн хэрэгслийн зөрчлийн тухай	1	1	
	Нийт	189	189	

Өргөдлийг шийдвэрлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулахад:

№	Өргөдлийн утга	Шийдвэрлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл
1	Хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох тухай	Иргэдээс ирүүлсэн 19 өргөдлийг хянаж үзэж, дүүргийн Засаг даргын 2024 оны Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох тухай А/05, А/36, А/37, А/133, А/141, А/175, А/226, А/232, А/266, А/322, А/357, А/372, А/404, А/407, А/466, А/467, А/490, А/489, А/493 дугаар захирамжуудыг гарган, асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.
2	Үрчлэлт тогтоох тухай	Иргэдээс ирүүлсэн 45 өргөдлийг хянан үзэж, дүүргийн Засаг даргын 2024 оны Хүүхэд үрчлүүлэх тухай А/20, А/21, А/22, А/25, А/30, А/31, А/35, А/39, А/42, А/48, А/51, А/58, А/161, А/162, А/168, А/176, А/214, А/265, А/267, А/268, А/283, А/302, А/323, А/373, А/374, А/375, А/398, А/405, А/408, А/409, А/420, А/421, А/425, А/426, А/509, А/516, А/519, А/538, А/539, А/557, А/578, А/592, А/593, А/602, А/605 А/628 дугаар захирамжуудыг гаргаж, дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлсэн.
3	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд харгалзан дэмжигч тогтоох тухай	Иргэдээс ирүүлсэн 29 өргөдлийг хянаж, дүүргийн Засаг даргын 2024 оны харгалзан дэмжигч тогтоох тухай А/02, А/11, А/12, А/29, А/38, А/40, А/57, А/89, А/117, А/218, А/220, А/221, А/262, А/263, А/264, А/278, А/319, А/335, А/336, А/438, А/452, А/520, А/533, А/534, А/589, А/601, А/619, А/633 дугаар захирамжуудыг гарган асран хамгаалагч, харгалзан дэмжигчидтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Хүсэлт ирүүлсэн Ч.Баатар нь Цэрэн-Уул төрийн бус байгууллагад 2024 оны 8 дугаар сараас одоог хүртэл асруулж байгаа, байнгын асаргаа, хөгжлийн бэрхшээлтэй болох нь тогтоогдоогүй, дүү Ч.Лхагва нь архины хамааралтай байсан зэргийг үндэслэн асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох боломжгүй болохыг төрсөн дүү Ч.Лхагвын 90040039 дугаарын утсанд мэдэгдсэн.
4	Ахмадын асрамжийн төвд асруулах тухай	Иргэдээс ирүүлсэн 4 өргөдлийг хянаж, дүүргийн Засаг даргын 2024 оны асрамжийн газарт асруулах тухай А/554, А/545, А/544, А/356 дугаар захирамжийг гарган Батсүмбэр дэх ахмадын асрамжийн газарт шилжүүлсэн.
5	Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах тухай	Иргэдээс ирүүлсэн 5 өргөдлийг хянаж, дүүргийн Засаг даргын 2024 оны Б.Болдбаатар, Б.Батбаяр нарыг шилжүүлэн асрамжлуулах тухай А/23, Б.Тэнүүнийг хүүхдийн төв сувилалд сувилуулах А/34, С.Анар, С.Ананд, С.Анирлан, С.Амар нарыг шилжүүлэн асрамжлуулах тухай А/72, З.Ууганбаяр, З.Уламбаяр нарыг шилжүүлэн асрамжлуулах тухай А/254, Л.Энхзаяаг гэр бүлд нь эргэн нэгтгэх тухай А/258, Г.Энгүүнийг шилжүүлэн асрамжлуулах тухай А/515 дугаар захирамжийг гарган асрамжийн газарт болон гэр бүлд нь эргэн нэгтгэсэн.

5.	Гэр хүссэн	<p>Гэр хүссэн 31 өргөдөл ирүүлсэнээс хорооноос ирүүлсэн нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар орж хэлэлцүүлэн 23 иргэнд гэр олгосон байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/85 дугаар захирамжаар 12 дугаар хорооны иргэн Г.Одонбатад 6,000,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн. Иргэн Г.Одонбаттай 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 15:30 цагт 88171077 утсаар холбогдон мэдэгдсэн. 2. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/86 дугаар захирамжаар 3 дугаар хорооны иргэн Н.Нямгэрэлд 6,000,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн. 3. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/87 дугаар захирамжаар 18 дугаар хорооны иргэн А.Тодгэрэлд 6,000,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн. 4. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/88 дугаар захирамжаар 15 дугаар хорооны иргэн Ч.Оюунчимэгт 6,000,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн. Иргэн Ч.Оюунчимэгтэй 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 15:30 цагт утсаар холбогдон мэдэгдсэн. 5. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар 09-ний өдрийн А/180 дугаар захирамжаар 19 дүгээр хорооны иргэн Я.Нямсүрэнд 6,000,000 төгрөгийн 5 ханатай иж бүрэн гэр олгохоор шийдвэрлэсэн. 6. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар 09-ний өдрийн А/181 дугаар захирамжаар 19 дүгээр хорооны иргэн Б.Саруултуяад 6,000,000 төгрөгийн 5 ханатай иж бүрэн гэр олгохоор шийдвэрлэсэн. 7. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар 09-ний өдрийн А/182 дугаар захирамжаар 15 дугаар хорооны иргэн Г.Хилийнчимэгт 6,000,000 төгрөгийн 5 ханатай иж бүрэн гэр олгохоор шийдвэрлэсэн. 8. 17 дугаар хорооны иргэн Н.Мөнхцэцэгийн гэр хүссэн хүсэлтийн дагуу хорооны Засаг даргын ажлын албаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн шийдвэрлэх боломжгүй болохыг иргэнд мэдэгдсэн. 9. 17 дугаар хорооны иргэн Г.Амаржаргалын гэр хүссэн хүсэлтийн дагуу хорооны Засаг даргын ажлын албаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн шийдвэрлэх боломжтой болохыг иргэнд мэдэгдсэн. 10. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар 09-ний өдрийн А/183 дугаар захирамжаар 12 дугаар хорооны иргэн Б.Нарангэрэлд 6,000,000 төгрөгийн 5 ханатай иж бүрэн гэр олгохоор шийдвэрлэсэн. 11. 17 дугаар хорооны Засаг даргын ажлын албаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн шийдвэрлэх боломжтой болохыг иргэнд мэдэгдсэн. 12. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/382 дугаар захирамжаар 12 дугаар хорооны иргэн Ч.Цэцэгмаад 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн. 13. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/383 дугаар захирамжаар 11 дүгээр хорооны
----	------------	--

		<p>иргэн И.Норжинсүрэнд 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>14. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/384 дүгээр захирамжаар 6 дугаар хорооны иргэн Э.Бадмаад 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>15. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/388 дугаар захирамжаар 9 дүгээр хорооны иргэн Т.Ядамжавд 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>16. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/389 дугаар захирамжаар 11 дүгээр хорооны иргэн О.Оюундарьд 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>17. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/381 дүгээр захирамжаар 12 дугаар хорооны иргэн Х.Санжид 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>18. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/390 дүгээр захирамжаар 12 дугаар хорооны иргэн Р.Лхагвадоржид 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>19. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/415 дугаар захирамжаар 15 дугаар хорооны иргэн Б.Ганбаатарт 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>20. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/412 дугаар захирамжаар 11 дүгээр хорооны иргэн М.Туулд 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>21. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/469 дүгээр захирамжаар 12 дугаар хорооны иргэн Т.Сүнжидмаад 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>22. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/501 дүгээр захирамжаар 12 дугаар хорооны иргэн О.Дарханцэцэгт 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>23. 12 дугаар хорооны иргэн Ц.Ариунжаргал хаягандаа амьдардаггүй, нөхцөл байдлын үнэлгээ хийх боломжгүй тул шийдвэрлэх боломжгүй гэсэн хариуг өгөв.</p> <p>24. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/503 дугаар захирамжаар 12 дугаар хорооны иргэн Т.Наранцогтод 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>25. М.Бадамсүрэн нь дүүргийн 11 дүгээр хороо 1-16 тоотод хаягтай боловч тус хаяг газарт орсон, Сонгино хайрхан дүүрэгт амьдардаг, гэрээ барих хашаа газаргүй тул өргөдлийг шийдвэрлэх боломжгүйг 94943406 дугаарын утсаар мэдэгдсэн.</p> <p>26. 12 дугаар хорооны иргэн Ц.Ариунжаргалын өргөдлийг Дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хаягандаа амьдардаггүй, нөхцөл байдлын үнэлгээ хийх боломжгүй тул шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгөв.</p> <p>27. 11 дүгээр хорооны хөгжлийн бэрхшээлтэй иргэн Б.Ням-Очирын орон сууц худалдан авсан 20% -ийн төлбөрөө шийдвэрлүүлэх хүсэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлж, хүсэлтийг шийдвэрлэх боломжгүй болохыг мэдэгдсэн.</p>
--	--	--

		<p>28. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/566 дугаар захирамжаар 13 дугаар хорооны иргэн О.Одонтунгалагт 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>29. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/567 дугаар захирамжаар 13 дугаар хорооны иргэн Н.Дэлгэрмаад 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>30. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/575 дугаар захирамжаар 17 дугаар хорооны иргэн Н.Мөнхцэцэгт 6,300,000 төгрөгийн үнэ бүхий 5 ханатай гэр олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>31. 17 дугаар хорооны иргэн Ц.Чимэддоржийн гэр хүссэн хүсэлтийн дагуу судалж шийдвэрлэх боломжгүй гэх хариуг өгсөн.</p>
6.	<p>Буцалтгүй мөнгө, яаралтай тусламж, эмчилгээ, нийгмийн халамж хүссэн</p>	<p>Буцалтгүй мөнгөн тусламж, эмчилгээний зардал, хүссэн 32 иргэний өргөдлийг хүлээн авч 29 шийдвэрлэн 3 өргөдлийг шийдвэрлэх боломжгүйг мэдэгдсэн байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/77 дугаар захирамжаар 12 дугаар хорооны иргэн Э.Хулангийн ээж Л.Сарангуагийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/78 дугаар захирамжаар 11 дүгээр хорооны иргэн Б.Анармаагийн охин Х.Маралмаагийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 3. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/79 дүгээр захирамжаар 11 дүгээр хорооны иргэн Д.Одонтунгалагийн хүү Т.Тэмүүлэнгийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 4. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/80 дугаар захирамжаар 17 дугаар М.Батгэрэлийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 5. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/81 дүгээр захирамжаар 17 дугаар хорооны иргэн Ш.Амаржаргалын эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 6. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/82 дугаар захирамжаар 19 дүгээр хорооны иргэн Г.Магнайн нөхөр Т.Буянхүүгийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 7. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/83 дугаар захирамжаар 16 дугаар хорооны иргэн Ж.Наранцэцэгийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 8. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/84 дүгээр захирамжаар 7 дугаар хорооны иргэн Б.Норжмаагийн эмчилгээний зардалд 2,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 9. Б.Бат нь 66 настай эмэгтэй ам бүл 3, бага хүү, ачийн хамт өрх толгойлон амьдардаг. 2 хүүхэд нь оюутан тул санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг хүссэн өргөдөл гаргасан ба үүний дагуу Нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийх гэсэн боловч завгүй гэх шалтгаанаар хийлгээгүй. Утсаар холбогдож ярьтал хөдөө явж байна өгсөн хүсэлтээ буцааж авч байна гэсэн хариу өгсөн. Үүний дагуу 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 11:20 минутад дүүргийн 502 тоотод уулзаж дүүргийн Засаг даргад хандаж гаргасан өргөдлийг нь буцааж хүлээлгэн өглөө.

	<ol style="list-style-type: none">10. Засаг даргын 2024 оны 05 дугаар 09-ний өдрийн А/188 дугаар захирамжаар иргэн Б.Болдбаатарын эмчилгээний зардал 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.11. Засаг даргын 2024 оны 05 дугаар 09-ний өдрийн А/190 дүгээр захирамжаар иргэн Ө.Нямсүрэнгийн эмчилгээний зардал 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.12. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/83 дугаар захирамжаар Цэрэндаваагийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.13. Засаг даргын зөвлөлийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар хурлаар иргэн Д.Лхагвагийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр болсон. Захирамжийн төсөлд санал авч байна.14. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/252 дугаар захирамжаар Г.Алтанцэцэгийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.15. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/284 дүгээр захирамжаар Ц.Пүрэвсүрэнгийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.16. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/317 дугаар захирамжаар Д.Аюушжавын эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.17. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/316 дугаар захирамжаар Ж.Энхзаяагийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.18. Дүүргийн 12 дугаар хорооны иргэн А.Ариунжаргалын мөнгөн тусламж хүссэн өргөдлийн дагуу хорооны Засаг даргын ажлын албаар нөхцөл байдлын үнэлгээ хийлгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулан хэлэлцүүлэн шийдвэрлэх боломжгүй болохыг мэдэгдсэн.19. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/318 дугаар захирамжаар Ж.Цэцгээгийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.20. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/414 дугаар захирамжаар Б.Уранжаргалын эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.21. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/468 дугаар захирамжаар Н.Гантуяагийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.22. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/470 дугаар захирамжаар Ч.Сарантуяагийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.23. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/471 дүгээр захирамжаар Б.Цэвэлмаад 10,000,000 төгрөгийн нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.24. П.Мөнхзулын өргөдлийг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн, үндсэн оршин суугч биш тул өргөдлийг шийдвэрлэх боломжгүй, амьдарч байгаа дүүрэгтээ хандахыг зөвлөсөн болно.25. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/500 дугаар захирамжаар А.Цэдэвсүрэнд
--	--

		<p>5,000,000 төгрөгийн нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>26. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/498 дугаар захирамжаар С.Сайхантуяад 5,000,000 төгрөгийн нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>27. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/502 дугаар захирамжаар Д.Уранбилэгийн эмчилгээний зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>28. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/568 дугаар захирамжаар Ч.Мөнхжаргалын 3,000,000 төгрөгийн нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>29. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/586 дугаар захирамжаар Н.Лхагвацэрэнгийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>30. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/618 дугаар захирамжаар Д.Отгоны эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>31. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/617 дугаар захирамжаар Х.Тэгшзаяагийн эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>32. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/625 дугаар захирамжаар Г.Оюунбатын эмчилгээний зардалд 3,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p>
7	Тэмцээний зардалд дэмжлэг хүссэн	<ol style="list-style-type: none"> 1. Дүүргийн 13-р хорооны иргэн Г.Гансүхийн хүү Б.Гүндалай Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо зохиогдсон Жюү Жицүгийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/184, захирамжаар 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 2. Дүүргийн 13-р хорооны иргэн Н.Оюунжаргалын хүү Б.Түвшинбаяр Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо зохиогдсон Жюү Жицүгийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь Засаг даргын 2024 оны 05 сарын 09-ний өдрийн А/185 захирамжаар 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 3. Дүүргийн 13-р хорооны иргэн Я.Эрдэнэзулын хүү Г.Чинхүслэн Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо зохиогдсон Жюү Жицүгийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь Засаг даргын 2024 оны 05 сарын 09-ний өдрийн А/186 захирамжаар 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 4. Дүүргийн 13-р хорооны иргэн Б.Даваа-Очирбын хүү Д.Чингүнжав Арабын Нэгдсэн Эмират Улсын Абу Даби хотноо зохиогдсон Жюү Жицүгийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь Засаг даргын 2024 оны 05 сарын 09-ний өдрийн А/187 захирамжаар 3 сая дэмжлэг үзүүлсэн. 5. Дүүргийн 13 дугаар хорооны иргэн Д.Наранхүү, нь хүүхдийнхээ тэмцээний зардалд дэмжлэг үзүүлсэнд талархал ирүүлснийг хүлээн авч, удирдлагуудад танилцуулсан. 6. Дүүргийн 13 дугаар хорооны иргэн Н.Оюунжаргал нь хүүхдийнхээ тэмцээний зардалд дэмжлэг үзүүлсэнд

		<p>талархал ирүүлснийг хүлээн авч, удирдлагуудад танилцуулсан.</p> <ol style="list-style-type: none"> 7. Дүүргийн 7 дугаар хорооны иргэн Ариунболдын охин А.Аялгуу, А.Мишээл нар нь төгөлдөр хуурчдын Олон Улсын тэмцээнд оролцоход дэмжлэг хүссэн тул 3 сая төгрөг шийдвэрлэсэн. 8. Дүүргийн 8 дугаар хорооны иргэн О.Удвалцэцэгийн хүү Ц.Тэмүүлэн туялзуур сэлэмний дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь Засаг даргын 2024 оны 04 сарын 08-ны А/134 захирамжаар 5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 9. Дүүргийн 11-р хорооны иргэн Х.Анандад Туялзуур сэлэмний дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд Засаг даргын 2024 оны 04 сарын 08-ны А/135 захирамжаар 4,5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 10. Дүүргийн 6 дугаар хорооны иргэн Э.Цолмонтуяагийн Таеквондогийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний зардалд Засаг даргын 2024 оны 07 сарын 08-ны А/320 захирамжаар 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 11. Дүүргийн 11 дүгээр хорооны иргэн Л.Банзрагчийн охин Тэргэлнаран жудо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээний зардалд дэмжлэг хүссэн тул Засаг даргын 2024 оны 07 сарын 08-ны А/315 захирамжаар 3 сая төгрөг шийдвэрлэсэн. 12. Дүүргийн 7-р хорооны иргэн С.Саранцэцэгийг Хүндийн өргөлтийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь Засаг даргын 2024 оны 08 сарын 20-ны өдрийн А/413 захирамжаар 2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. 13. Дүүргийн 14-р хорооны иргэн Д.Үүрийнтуяа нь охин Ү.Отгонжаргалын тэмцээний зардалд дэмжлэг хүссэн тул Засаг даргын 2024 оны 09 сарын 20-ны А/499 захирамжаар 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
8	Талархал	СБД-ийн Засаг дарга Болормаад талархал илэрхийлсэн 4 өргөдөл байна.
9	Гомдол	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 38.1-д хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ гэж заасны дагуу иргэн Удвалд 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдөр үнэмлэхийг олгож, гомдлыг шийдвэрлэсэн. 2. Иргэн Г.Энхбатын ирүүлсэн гомдолын дагуу холбогдож сургуульд албан бичиг хүргүүлэн, захиралтай уулзаж, зөвшөөрөл авсаны үндсэн дээр бэлтгэл хийхийг зөвлөсөн. Мөн 6 дугаар сургуулийн захирал Түвшинсайхантай холбогдож, албан бичгийг хүлээн авч, дэмжиж ажиллах талаар мэдэгдсэн болно. 3. Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу тухайн иргэнтэй нь холбогдож тодруулан тухайн барилгын ажлыг хариуцаж байгаа ТГУХ-т мэдэгдэн ажиллаж байна.
10	Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай	<ol style="list-style-type: none"> 1. Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр ханган, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. хэмээн заасан бөгөөд тус дүүргийн Насан туршийн Боловсролын төв нь 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт 30 гаруй багш ажилтантай үйл ажиллагаа явуулж, боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 83 насанд хүрэгч, өргөө амржих газрын 50 гаруй иргэдэд монгол бичгийн сургалт явуулах үйлчилгээ үзүүлж буй зэрэг тогтмол үйл

		<p>ажиллагаатай байгууллага юм. Иргэнд төвийн мэдээлэл, хаяг, холбоо барих утас, фэйж хаягийн мэдээлэл хүргүүлсэн.</p> <p>2. Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь заалтын дагуу ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн хамран сургах тойргийг тус дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн хүрээнд Нийслэлийн Боловсролын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/48 дугаар тушаалаар тогтоосон. Иймд хамран сургах тойргийн бус буюу Баруун чиглэлд сургуулийн автобусны үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна.</p>
11	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн тохижилтын тухай	<p>1. Гомдол гаргасан байршилд Нэст эдүкэшн сургуулийн орчмын газар дээр нь очиж үзэхэд 4 автобус зогсоолд 1 автобус зорчих хэсгийн 1 урсгалыг хаасан байдалтай байсан. Сургуулийн үйл ажиллагаа хариуцсан менежер Баасанхүүтэй биечлэн уулзаж, зорчих хэсэгт байрлуулсан 1 автобусыг зориулалтын зогсоолд байрлуулах шаардлага хүргүүлж, шийдвэрлэсэн. Гомдол гаргасан иргэнтэй утсаар холбогдож, дахин зөрчил илэрвэл мэдэгдэхээр ярилцсан.</p> <p>2. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлын 2022 оны Нийгмийн дэд бүтцэд хамаарах хотын стандарт батлах тухай 19 дүгээр тогтоолын дагуу 69 дүгээр цэцэрлэгийн гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар 2024 оны 6 дугаар сарын 01-10-ны хооронд хааж, иргэдийн хүсэлтийн дагуу тоглоомын талбайгаа 10-ны өдрөөс нээсэн болно.</p> <p>3. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлын 2022 оны Нийгмийн дэд бүтцэд хамаарах хотын стандарт батлах тухай 19 дүгээр тогтоолын дагуу 69 дүгээр цэцэрлэгийн гадна ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулахаар 2024 оны 6 дугаар сард түр хугацаагаар хаасан. Цаашид оршин суугчдын хүүхэд тоглох боломжийг бүрдүүлэн тоглоомын талбайгаа нээж ажиллах болно.</p> <p>4. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөлөгчдийн Хурлын 2022 оны Нийгмийн дэд бүтцэд хамаарах хотын стандарт батлах тухай 19 дүгээр тогтоолоор Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага стандарт баталсан. Тус 4 дүгээр сургуулийн сагсан бөмбөгийн талбайн хажууд айл, өрхүүдийн өндөр хүчдэлийн шугам байрлаж буйгаас шатгаалж, сагсан бөмбөгийн талбайг ашиглах боломжгүй болж, өдий хүртэл ашиглаагүй байна. Мөн хөлбөмбөгийн талбайг буулгаж, 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар өргөтгөлийн барилга барихаар тендер шалгаруулалтын ажил хийгдэж байна. Иймд дээрх 2 шалтгааны улмаас сагс, хөл бөмбөгийн талбайг ашиглах боломжгүй байна.</p>
12	Барилга, байгууламж барих, өргөтгөх тухай	<p>Сүхбаатар дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэр 159 дүгээр сургуулийн зүүн талд дүүргийн эмнэлэг, зүүн урд талд 248-р цэцэрлэгийн өргөтгөл баригдаж байгаатай холбогдуулан багш, ажилтны машин тавьдаг байрлалд түр зуурын хүндрэл гарч хаасан. Сургуулийн зүүн хэсгийн гарцыг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр нээж, сургуулийн багш, ажилтнуудын машины зогсоолтой холбоотой гомдлыг шийдвэрлэсэн.</p>

13	Том оврын тээврийн хэрэгслийн зөрчлийн тухай	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу (25.2.2. үйлдвэрлэлийн осол, аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллөөс иргэдийг хамгаалах, сэрэмжлүүлэхэд чиглэсэн арга хэмжээнд байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах; 29.2.Ажил олгогч нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарах бүрд Засгийн газраас тогтоосон журмын дагуу осол, хурц хордлогыг тогтоох, судлан бүртгэх үүрэгтэй бөгөөд осол, хурц хордлогын шалтгааныг тогтоох акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг байгуулж ажиллуулна) “Хонгор бээс транс” компани нь хохирлыг барагдуулах үүрэгтэйг иргэнд 99201022 утсаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2023 оны А/441 дүгээр захирамжаар байгуулагдсан Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисст өргөдлийг танилцуулж, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөрийн хяналтын мэргэжилтэн, Улсын байцаагч (Ч.Отгонжаргал 96071918) мэргэжил, аргазүйн чиглэл өгч, хариуцан ажилласан.
----	--	---

Хүүхдийг үрчлүүлэх 46, асран хамгаалагч, хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд харгалзан дэмжигч тогтоох 48 шийдвэр тус тус гаргаж, хүний эрхийг хангаж ажилласан.

2024 оны 4 дүгээр улиралд өөрийн гэсэн гэр оронгүй, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас орон гэргүй болсон 23 өрхөд Засаг даргын шийдвэрээр гэр олгож, амьдралын чанарт дэмжлэг үзүүлсэн.

Буцалтгүй мөнгөн тусламж хүссэн 29 иргэнд дүүргийн Засаг даргын захирамжаар нийт 115,000,000 сая төгрөгний буцалтгүй мөнгөн тусламж олгож, эрүүл мэнд болон хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг зохион байгуулсан.

2024 оны 04 дүгээр улирлын байдлаар нийт 189 өргөдөл хүлээн авч 9 хоног 23 цаг 22 минут хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр:

Тус хэлтэст хандаж иргэдээс худалдаа, үйлчилгээний чанар аюулгүй байдлын талаар 60, хоол үйлдвэрлэл, орон сууцны 1 дүгээр давхрын үйлчилгээний талаар 38, нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулсан ТҮЦ-ийн талаар 94, хүнсний ногооны худалдааны цэгийн талаар 3, нийт 195 өргөдөл гомдол, 2 талархал ирснээс ихэнх хувийг ТҮЦ-үүдийг нүүлгэн шилжүүлэх, гар дээрх ил задгай худалдааг цэгцлэх гомдлууд эзэлж байна. Иргэдийн гомдлыг барагдуулах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Гар дээрх ил задгай худалдаа, үйлчилгээ, ТҮЦ-ийн үйл ажиллагааг цэгцлэх ажлын хүрээнд жижиг бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангуулж ажиллах талаар дүүргийн Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл нийт 5 удаа хуралдаж, 66 байршилд худалдааны 28 цэг, хоол үйлдвэрлэлийн 38 цэгт улирлын чанартай түр худалдаа, үйлчилгээ эрхлэх тоог тогтоож, ААН, иргэдийн хүсэлтийг Онлайн бизнес төв цахим сайтаар дамжуулан авч, НХХААГ-ын Хяналтын хэлтэстэй хамтран худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хүнсний аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн, зөвлөмж гардуулан, үйлчилгээний чанар аюулгүй байдалд хяналт тавин ажилласан.

Дүүргийн 1-10, 11, 12, 14, 16, 20 дугаар хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд зуны түр үйлчилгээ явуулж буй 66 иргэн, ААН-үүдэд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөр үйл

ажиллагаагаа зогсоож, нийтийн эзэмшлийн зам талбай чөлөөлөх тухай Мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам, дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 10-ны Түргэн үйлчилгээний цэгүүдийг нүүлгэж, нийтийн эзэмшлийн зам, талбайг чөлөөлөх тухай А/212 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 7 дугаар хорооны 8, 9 дүгээр байрны дундах 1, 8 дугаар хорооны МУИС-ийн Бизнесийн их сургуулийн урд талаас 1, Хангай хотхон Номин супермаркетийн баруун урд талаас 2, Сөүл эмнэлгийн зүүн талаас 5, Нийслэлийн Авто замын газраас хийж буй явган болон дугуйн замын тохижилтын ажлын хүрээнд 3-р сургуулийн урд байрлаж буй 8 ТҮЦ-ийг дүүргийн ГЗА-тай хамтран, иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Цэрэндоржийн гудамжид зөвшөөрөлгүй байрлуулсан зуны үйлчилгээний 4, Урчуудын эвлэлийн төв байрны араас 2 явуулын хоолны үйлчилгээг албадан нүүлгэж, нийт 23 ТҮЦ-ийг албадан нүүлгэж, нийтийн эзэмшлийн талбайг чөлөөлсөн.

Мөн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдөр иргэдээс удаа дараа гомдол ирүүлж буй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд хүнсний бүтээгдэхүүн худалдаалсан, орчны цэвэрлэгээг хангалтгүй хийдэг нэн тэргүүнд нүүлгэх шаардлагатай ТҮЦ-үүдийн (42) судалгааг хороодын Ажлын албатай хамтран гаргасан.

Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт болон дээд байгууллагаас гаргасан шийдвэр, холбогдох мэдээ, мэдээллийг СБД-ийн ЗДТГ пейж хуудас, нээлттэй СБД пейж хуудас, СБД-ийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс пейж хуудас, СБД хоол үйлдвэрлэл, үйлчилгээ фэйсбүүк групп, СБД-Худалдаа, СБД-Зах, худалдааны төвүүд, СБД-үйлдвэрүүд, SBD food чат групп, ХХҮХ-Хороод бүлэг, СБД-ийн 1-10 дугаар хороо, Хойд хороод 11-20 дугаар хороодын мессенжерийн бүлэг чат зэрэг олон нийтийн цахим мэдээллийн сүлжээгээр дамжуулан сурталчилж байна.

ХЯНАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



В.ГОМБОДОРЖ

ТАЙЛАН ГАРГАСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Д.ЧИМЭДДУЛАМ